Golomt Capital®

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2025.06.02

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын Олон Улсын Худалдааны Шүүх Трамп ерөнхийлөгч ихэнх тарифуудыг хууль бусаар хэрэгжүүлсэн гэж дүгнэн, хүчингүй болгох шийдвэр гаргасан.
- Сангийн сайд Скотт Бессентын Хятад-АНУ-ын худалдааны хэлэлцээ "жаахан гацсан" хэмээжээ.
- Core PCE өмнөх оны мөн үеэс 2.5%-иар өссөн гэж мэдээлэв. Энэ нь 3-р сард бүртгэгдсэн 2.7%-аас буурсан үзүүлэлт бөгөөд 2021 оноос хойших хамгийн бага жилийн инфляцийн түвшин болсон.
- Хэрэглэгчдийн Итгэлийн Индекс таван сар дараалан буурсны дараа 5-р сард огцом сэргэж, 12.3 нэгжээр өсч 98-д хүрсэн байна.
- Хятад улс ойролцоогоор 500 тэрбум юань (70 тэрбум ам.доллар)-ыг шинэ дэд бүтцийн төслүүдэд хуваарилахаар төлөвлөж байна.
- БНХАУ Женевт АНУ-тай хийсэн хэлэлцээрийн хүрээнд хүрсэн зөвшилцлийг тууштай авч үзэж, хатуу чанд хэрэгжүүлж, идэвхтэй дагаж мөрдөж байгаа" гэж онцолжээ.

S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	**6,678**

АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.05.26-06.01

АНУ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ХУРААНГУЙ

АНУ-ын хувьцааны зах зээлд хөрөнгө оруулагчдын зүгээс шахалт үүсч, гол индексүүд оргил түвшнээсээ доогуур хаагдлаа. Nasdaq Composite индекс 2.01%-иар өсч тэргүүлсэн бол S&P 500 индекс 1.88%, Dow Jones Industrial Average 1.60%-иар нэмэгдсэн байна. Харьцангуй жижиг зах зээлийн хувьцаанууд арай сул үзүүлэлттэй байсан ч нийт зах зээл ерөнхийдөө эерэг өсөлттэй долоо хоногийг дуусгав.

Долоо хоногийн эхэнд хөрөнгө оруулагчдын сэтгэл зүйд нааштай нөлөө үзүүлсэн үйл явдал нь Ерөнхийлөгч Дональд Трамп Европын Холбооноос импортлох бараанд ногдуулах 50%-ийн шинэ тарифыг долдугаар сарын 9 хүртэл хойшлуулж, хоёр талын худалдааны яриа хэлэлцээг “хурдасгана” гэж амласан мэдэгдэл байв. Харин долоо хоногийн дунд үед АНУ-ын Олон Улсын Худалдааны Шүүх Трамп ерөнхийлөгч хоёрдугаар бүрэн эрхийн хугацааны турш хэрэгжүүлсэн ихэнх дэлхийн хэмжээний тарифуудыг хууль бусаар хэрэгжүүлсэн гэж дүгнэн, хүчингүй болгох шийдвэр гаргасан нь пүрэв гарагийн өглөө хувьцааны ханшийг огцом өсгөсөн. Гэвч тус шийдвэрийг АНУ-ын засаг захиргаа яаралтай давж заалдан, холбооны давж заалдах шатны шүүх шийдвэрийн гүйцэтгэлийг түр зогсоосноор долоо хоногийн эцэст хөрөнгийн зах зээл хэсэгчлэн уналт хийсэн.

Мөн Сангийн сайд Скотт Бессентын Хятад-АНУ-ын худалдааны хэлэлцээ “жаахан гацсан” гэсэн мэдэгдэл, түүнчлэн Ерөнхийлөгч Трампын зүгээс олон нийтийн сүлжээнд Хятад улс урьдчилсан хэлэлцээрээ зөрчсөн байж болзошгүй талаар баталгаагүй мэдээлэл түгээсэн нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулсан хүчин зүйлүүд байв.

АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний товчоо (BEA) 4-р сарын үндсэн хувийн хэрэглээний үнийн индекс (core PCE) өмнөх оны мөн үеэс 2.5%-иар өссөн гэж мэдээлэв. Энэ нь 3-р сард бүртгэгдсэн 2.7%-аас буурсан үзүүлэлт бөгөөд 2021 оноос хойших хамгийн бага жилийн инфляцийн түвшин болсон ч, Fed-ийн урт хугацааны зорилтот 2%-ийн түвшнээс өндөр хэвээр байна. Хэдий 4-р сарын энэхүү өгөгдөл инфляц буурах хандлагыг илтгэж байгаа ч, олон шинжээч тарифын нөлөө бүрэн илрэх хугацаа нь энэ зуны сүүлээр тохионо гэж үзэж байна. Түүнчлэн, Холбооны Нөөцийн Сангийн 5-р сарын 6–7-ны хурлын протокол лхагва гарагт нийтлэгдсэн бөгөөд тус хуралдаанд оролцогчид “инфляцийн төлөвийн эрсдэл нь өсөх чиглэлтэй хэвээр байна” хэмээн дүгнэжээ. Энэ нь голчлон “худалдааны бодлого болон бусад эдийн засгийн бодлоготой холбоотой тодорхойгүй байдал”-тай холбоотой гэж тэмдэглэсэн байна.

The Conference Board байгууллагаас танилцуулсан Хэрэглэгчдийн Итгэлийн Индекс таван сар дараалан буурсны дараа 5-р сард огцом сэргэж, 12.3 нэгжээр өсч 98-д хүрсэн байна. Уг өсөлт нь хэрэглэгчдийн ирээдүйн хүлээлт сайжирсантай шууд холбоотой гэж The Conference Board-ын Глобал Үзүүлэлт хариуцсан ахлах эдийн засагч Стефани Гичард тайлбарлав. Тэрээр “Итгэл сэргэх хандлага аль хэдийн 5-р сарын 12-ны АНУ-БНХАУ-ын худалдааны хэлэлцээрээс өмнө илэрч байсан ч, энэхүү хэлэлцээрийн дараа энэ өсөлт эрчээ улам авсан. Мичиганы Их Сургуулиас нийтэлсэн Хэрэглэгчийн Сэтгэлзүйн Индексийн 5-р сарын эцсийн үзүүлэлт нь 4-р сарынхаас өөрчлөгдөөгүй, The Conference Board-ын судалгаатай адилаар, хэрэглэгчдийн хандлага 5-р сарын сүүлийн хагаст мэдэгдэхүйц нааштай эргэж, АНУ-БНХАУ-ын тарифын түр завсарлага нь эдийн засгийн төлөвт үзүүлэх итгэлийг сайжруулсан нь тодорхой болжээ. Гэвч аль аль судалгаанд хэрэглэгчдийн инфляцийн хүлээлт өндөр түвшинд хадгалагдсаар байна.

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.05.26 – 06.01

ХЯТАДЫН ДАРААГИЙН 5 ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хятадын эх газрын хувьцааны зах зээл энэ долоо хоногт буурсан үзүүлэлттэй хаагдлаа. АНУ-аас үүдэлтэй худалдааны дайны түр завсарлага болон эдийн засгийн гол үзүүлэлтүүд багатай, нам гүм долоо хоног нь хөрөнгө оруулагчдын худалдан авах эрмэлзэлд сөргөөр нөлөөлжээ.

FactSet-ийн мэдээллээр, дотоодын CSI 300 индекс 1.08%-иар, Шанхайн Композит индекс 0.03%-иар буурсан бол Хонконгийн Hang Seng индекс 1.32%-ийн уналттай байв. Тавдугаар сард АНУ болон Хятадын хооронд хийсэн хэлэлцээрийн үр дүнд тарифын дайнд түр завсарлага тогтоосны дараа, Бээжин улс орны эдийн засгийг хамгаалахын тулд илүү идэвхтэй арга хэмжээ авч эхэлжээ.

Bloomberg агентлаг нэрээ нууцалсан эх сурвалжаас иш татан мэдээлснээр, Хятад улс ойролцоогоор 500 тэрбум юань (70 тэрбум ам.доллар)-ыг шинэ дэд бүтцийн төслүүдэд хуваарилахаар төлөвлөж байна. Энэхүү “шинэ санхүүжилтийн бодлогын хэрэгсэл”-ийн хүрээнд улсын гурван бодлогын банк хөрөнгө босгож, хиймэл оюун ухаан, дижитал эдийн засаг болон хэрэглээтэй холбоотой дэд бүтцийн төслүүдэд хувь эзэмшигч хэлбэрээр оролцох юм.

Үүнээс гадна, 2026 оноос эхлэх Хятадын дараагийн “Таван жилийн төлөвлөгөө”-г боловсруулах үүрэгтэй албаны хүмүүс үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувийг урт хугацаанд тогтвортой түвшинд хадгалах талаар судалгаа хийж байгааг Bloomberg мөн мэдээлжээ. Хэдий уг төлөвлөгөө эцэслэн батлагдаагүй ч, Хятад улс үйлдвэрлэлд суурилсан эдийн засгийн стратегиа хадгалах бодолтой байгааг илтгэж байна. Гэхдээ АНУ болон Европ энэ стратегийг худалдааны тэнцвэргүй байдал үүсгэж буй хэмээн шүүмжилсээр байна.

ХЯТАД НЬ ТРАМПЫН МЭДЭГДЛИЙГ НЯЦААЛАА

БНХАУ-ын Худалдааны яам даваа гарагт АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын "Хятад нь Женевт байгуулсан сүүлийн үеийн худалдааны тохиролцоог зөрчсөн" гэх мэдэгдлийг эрс няцаалаа. Хятадын Худалдааны яам мэдэгдэлдээ: “БНХАУ Женевт АНУ-тай хийсэн хэлэлцээрийн хүрээнд хүрсэн зөвшилцлийг тууштай авч үзэж, хатуу чанд хэрэгжүүлж, идэвхтэй дагаж мөрдөж байгаа” гэж онцолжээ.

Мөн мэдэгдэлд: “АНУ үндэслэлгүй гүтгэлэг тарааж, Хятадыг зөвшилцлийг зөрчсөн гэж буруутгаж байгаа нь бодит байдлаас ноцтой зөрж байна” хэмээн тэмдэглэсэн байна. “Хятад улс эдгээр үндэслэлгүй буруутгалыг хатуу няцааж байна” гэж тус яам нэмж мэдэгджээ. Өнгөрсөн долоо хоногийн сүүлээр Ерөнхийлөгч Трамп Женевийн тохиролцооны хэд хэдэн заалтыг Хятад зөрчсөн гэж мэдэгдсэн боловч яг ямар заалтыг зөрчсөн талаар тодорхой мэдээлэл өгөөгүй юм. Женевийн хэлэлцээрийн хүрээнд Бээжин, Вашингтон хоёр харилцан тарифыг бууруулсан ч, талуудын үг хэллэг, хандлага хурц хэвээр үлджээ. Хятад улс АНУ-ын зүгээс хагас дамжуулагчийн салбарт нь тавьж буй экспортын хязгаарлалтыг байнга шүүмжилж, энэ нь Женевийн тохиролцоог сулруулах эрсдэлтэй гэж мэдэгдсээр ирсэн. Мөн өнгөрсөн долоо хоногт Трампын засаг захиргаа Хятадтай хийж буй яриа хэлэлцээ гацсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд харилцааг сэргээхийн түлд Ерөнхийлөгч Си Жиньпин, Дональд Трамп хоёрын шууд уулзалт шаардлагатай болж магадгүй гэж мэдэгдсэн юм. АНУ болон БНХАУ энэ онд өндөр хэмжээний харилцан тарифын тэмцэлд орсон бөгөөд АНУ-ын анхны хатуу тарифын дараа Хятад ч хариу татвар тогтоосон. Хэдий Женевийн хэлэлцээрээр тарифын түвшин буурсан ч, түүхэн дээд хэмжээндээ ойр түвшинд хэвээр байна. Сүүлийн үеийн эдийн засгийн олон үзүүлэлтүүд тариф Хятадын эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөг харуулсаар байна.

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд